Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр /сая төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хүрсэн түвшин /бичвэр/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ** | | | | | | | | |
| | Зорилт 1. Хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | - | Боловсруулж батлуулсан баримт бичгийн тоо | 12 | 3 | 6 | Хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 12 арга хэмжээ дэвшүүлж 96,5 хувийн гүйцэтгэлтэй байна. | 96,5 |
| | | | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 10 | 5 | 5 | | |
| | | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 | 2 | 2 | | |
| 1 | Арга хэмжээ 1.1 Харилцаа холбооны хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллах | - | Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд өгсөн саналын тоо | 3 | 4 | 4 | 1. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллаж 30 дугаар зүйл 3 санал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2 санал оруулж ажилласан. | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. Харилцаа холбооны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 "Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харилцаа холбооны улсын байцаагч ажиллаж болно." гэсэн заалт нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 зүйлд заасантай нийцэхгүй байгаа тул хүчингүй болох, мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.50 дахь заалт буюу харилцаа холбооны хяналтын улсын байцаагчийн харьяалалд Зөрчлийн тухай хуулийн 14.15, 15.34 дүгээр зүйлийг нэмэх шаардлагатай талаар санал боловсруулж Хяналт үнэлгээний Үндэсний хороонд хүргүүлсэн. | |
| 2 | Арга хэмжээ 1.2 Шуудангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллах | - | Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд өгсөн саналын тоо | 0 | 1 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/73 дугаар тушаалаар Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна. | 100 |
| 3 | Арга хэмжээ 1.3 Хот байгуулалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллах | - | Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд өгсөн саналын тоо | 0 | 1 | 1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 79 дугаар тушаалын дагуу Хот байгуулалтын тухай хуулийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж 2025 оны 01 дүгээр сарын 10 өдөр ажлын хэсгийн хуралдаанд оролцож харилцаа холбооны шугам сүлжээний хамгаалалтын зурвас газрын талаар мэдээлэл хийв. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Арга хэмжээ 1.4 Радио долгионы тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллах | - | Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд өгсөн саналын тоо | 0 | 1 | 1 | Радио долгионы тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдахаар төлөвлөгдсөн ба ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах саналыг холбогдох албан тушаалтанд мэдэгдсэн болно. | 90 |
| 5 | Арга хэмжээ 1.5 Харилцаа холбооны салбарт шинээр болон шинэчлэн боловсруулсан стандарт, норм дүрмийн төсөлд санал өгөх. | - | Стандарт, норм, дүрмийн төсөлд өгсөн саналын тоо | 6 | 5 | 3 | 1. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А/144 дугаар тушаалаар Харилцаа холбооны стандартчиллын техникийн хорооны гишүүнээр ажиллаж 2025-2026 оны Стандартын хөтөлбөрт багтсан стандартуудыг боловсруулахаар ирүүлсэн багуудын холбогдох мэдээлэлтэй танилцаж санал өгөв. 2. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны А/272 тоот тушаалаар Шуудан холбооны стандартуудын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллаж Шуудан хэрэглэгдэхүүн, 1-р хэсэг, Шуудангийн тэмдэг MNS 5380-1:2004, Шуудан хэрэглэгдэхүүн, 2-р хэсэг, Шуудангийн маягт MNS 5380-2:2004, Шуудангийн аюулгүй байдал MNS 5539:2019 стандартуудад үзлэг хийж, батлагдсан маягтын дагуу шинэчлэх саналаа боловсруулан 2024 оны 12 дугаар сард Харилцаа холбооны зохицуулах хороонд narantsetseg@crc.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн бөгөөд 2025 оны 02 дугаар сард үзлэгийн нэгдсэн дүнг хэлэлцэж, стандартын хороонд хүргүүлсэн. | 100 |
| 6 | Арга хэмжээ 1.6 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 5, МУ-ын Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолоор баталсан | - | Шинээр боловсруулж батлуулсан эрх зүйн | 7 | 5 | 4 | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 5, МУ-ын Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Хяналтын байцаагчийн эрх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | “Хяналтын байцаагчийн эрх олгох цуцлах журам”-ын дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлэх алба хаагчдад улсын байцаагчийн эрх олгох, цуцлах үнэмлэх тэмдэг олгуулах эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах | | баримт бичгийн тоо | | | | олгох цуцлах журам”-ын дагуу сайдын 2025 оны Б/14 дугаар тушаалаар Э.Ихмонголд Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчийн эрхийг олгох, Б/08, Б/13, Б/19 дугаар тушаалаар Б.Баттулга, Х.Мухаметали, Г.Нарангэрэл нарын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчийн эрхийг цуцлах, нийт 4 тушаал гаргаж, шийдвэрүүдийг албажуулсан. | 100 |
| 7 | Арга хэмжээ 1.7 Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчдын үнэмлэх хийлгэх зардлын төсөв тооцоог боловсруулах, захиалж хийлгэх, улсын байцаагч нарт хуваарилах | - | Улсын байцаагчийн үнэмлэхний тоо | 5 | - | 2 | 1. Улсын ахлах байцаагчийн үнэмлэх хийлгэх зардлын төсөв тооцоог боловсруулах, Дэлбакс ХХК-д 5 ширхэг улсын ахлах байцаагчийн үнэмлэхний хавтсыг захиалан хэвлүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2. Сүхбаатар аймгийн Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Э.Ихмонголын үнэмлэх, тэмдгийг Шүрэн тамга ХХК-д захиалан хийлгэсэн. | 100 |
| 8 | Арга хэмжээ 1.8 Салбарын хяналт шалгалтад хамаарах объектын жагсаалтыг боловсруулж, салбарын сайдаар батлуулах | - | Шинээр боловсруулж батлуулсан баримт бичгийн тоо | 1 | 1 | - | Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг журамд заасны дагуу 11 дүгээр сарын 10-аас 25-ны хооронд хийж гүйцэтгэнэ. /хугацаа болоогүй/ | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Арга хэмжээ 1.9 Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж батлуулах. | - | Шинээр боловсруулж батлуулсан баримт бичгийн тоо | 4 | 7 | 2 | 1. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын хуудсыг шинээр болон шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах 20250603028 дугаартай ажлын даалгавар боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.<br>09.05 кодтой “Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөлтэй этгээдийг шалгах” 09.06 кодтой “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох этгээдийг шалгах” хяналтын хуудаснуудыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын тушаалтын төслийн хамт хянуулахаар газрын даргад танилцуулсан.<br>2. Шуудангийн үйлчилгээ эрхлэгч этгээдийг шалгах хяналтын хуудасны загварыг боловсруулж, бусад улсын байцаагч болон оролцогч талуудаас санал авах, боловсронгуй болгох, зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тусгах ажил хийгдсэн. | 80 |
| 10 | Арга хэмжээ 1.10 Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийн эрсдэлийг үнэлж 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлэх. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 1 | 1 | - | Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг журамд заасны дагуу 11 дүгээр сарын 10-аас 25-ны хооронд хийж гүйцэтгэнэ. /хугацаа болоогүй/ | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Арга хэмжээ 1.11 Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах | - | Зөвлөмжийн тоо | 1 | 1 | 3 | Аймгийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хяналт шалгалтын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Зэвсэгт хүчний жанжин штабын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын (ахлах) байцаагчид цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын бодлого, чиглэл, хууль эрх зүй, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах нэгдсэн арга хэмжээг 2025 оны 04 дугаар сарын 23, 24, 25-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа.Сургалтад мэдээлэл, харилцаа холбооны хяналтын 31 улсын байцаагч хамрагдсан. Тус арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Салбарын хяналтын газрын дарга С.Цагаанхүү нээж, хяналт шалгалтын арга хэлбэрийг илүү боловсронгуй болгох, хяналт шалгалтаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулж буй бэрхшээл, хүндрэлийг хөнгөвчлөх, хяналт шалгалтын давхардлыг арилгах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, аливаа аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулан иргэд, аж ахуйн нэгжүүдийн талархлыг хүлээсэн шинэчлэлт, өөрчлөлтийг хийж ажиллахыг улсын (ахлах) байцаагчдад чиглэл болголоо.Сургалтын арга хэмжээг “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын хяналт, шалгалтын бодлого, чиглэл, хууль тогтоомж, анхаарах асуудал”, “Хиймэл оюун ухааныг салбарын хяналт шалгалтад үр дүнтэй ашиглах, хувь хүний хөгжлийн багц сургалт” гэсэн 2 үндсэн бүлэг сэдвийн хүрээнд зохион байгуулсан ба энэ хүрээнд | 100 |
| | | | Зохион байгуулсан сургалтын тоо | 1 | 1 | 2 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцогч байгууллагууд болох Нийслэлийн прокурорын газар, Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнууд, Хяналт, үнэлгээний үндэсний хороо, Монгол Улсын Их Сургууль, Мэдээлэл холбооны технологийн сургууль, Монголын үндэсний их сургууль, "Глобал талент менежмент" сургалтын байгууллагын сургагч багш нар хөтөлбөрийн дагуу илтгэл танилцуулга хийж, мэдээлэл солилцон, мэдээлэл, харилцаа холбооны салбарт тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.<br>2. Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилготой "Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-г хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд эрх бүх албан тушаалтнуудад зориулсан сургалтыг Монгол Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран зохион байгуулах талаар Харилцаа холбооны зохицуулах хороо, Зэвсэгт хүчний жанжин штабт 02/1145 дугаар, Нийслэлийн хяналт шалгалтын газарт 02/1159 дугаар албан бичгийг тус тус хүргүүлж сургалтыг 5 дугаар сарын 22 өдөр зохион байгуулсан бөгөөд тус сургалтад 18 мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчид хамрагдсан. | |
| 12 | Арга хэмжээ 1.12 Яамны 2024-2028 стратегийн төлөвлөгөөнд салбарын хяналтын газрын чиг үүрэг, | - | Өгсөн саналын тоо | 0 | 1 | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024-2028 оны стратегийн төлөвлөгөөнд Салбарын хяналтын газрын чиг үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний саналыг боловсруулж Бодлого төлөвлөлтын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний саналыг боловсруулж холбогдох газарт хүргүүлэх. | | | | | | газрын ахлах шинжээчид хүргүүлсэн ба сайдын тушаалаар стратеги төлөвлөгөө батлагдсан. | |
| **ХОЁР. Салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангуулах** | | | | | | | | |
| Зорилт 2. Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг удирдана. | | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 0 | 5 | - | Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг удирдана" зорилтын хүрээнд 5 арга хэмжээ төлөвлөн 3 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай, 2 арга хэмжээний хугацаа болоогүй байна. | 100 |
| 13 | Арга хэмжээ 2.1 Эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэх боловсруулж, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж хүргүүлэх. | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 0 | 1 | - | Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг журамд заасны дагуу 11 дүгээр сарын 10-аас 25-ны хооронд хийж гүйцэтгэнэ. /хугацаа болоогүй/ | - |
| 14 | Арга хэмжээ 2.2 Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх | - | Хяналт шалгалтын нийт объектод эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан объектын эзлэх хувь | 0 | 10 | - | Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг журамд заасны дагуу 11 дүгээр сарын 10-аас 25-ны хооронд хийж гүйцэтгэнэ. /хугацаа болоогүй/ | - |
| 15 | Арга хэмжээ 2.3 Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhyanalt.gov.mn цахим системийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо | 18 | - | 2 | Зам тээврийн яамны 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 11/940 албан бичгийн дагуу зам тээврийн салбарын хяналтын улсын (ахлах) улсын байцаагч нарт 2025.03.11 -ний өдөр Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhyanalt.gov.mn цахим системийн ашиглалт, анхаарах асуудал | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сэдвээр сургалт сургалт зохион байгуулсан.<br>Хяналт, үнэлгээний үндэсний хорооны хүсэлтээр 11 яам 2 төрийн захиргааны байгууллагын www.shilenkhyanalt.gov.mn зохицуулагч нарт 2025.03.13-ний өдөр “Цахим системд гарч байгаа нийтлэг алдаа, алдаа дутагдлыг арилгах” сэдвээр сургалт зохион байгуулж ажиллаа. | |
| 16 | Арга хэмжээ 2.4 Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhyanalt.gov.mn цахим системийн нэвтрэх эрх олгох асуудлыг зохицуулах | - | Нэвтрэх шаардлагатай байгууллагын тоо | 15 | - | - | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан www.shilenkhyanalt.gov.mn цахим системийн нэвтрэх эрх олгох хүсэлт ирүүлээгүй байна. | - |
| 17 | Арга хэмжээ 2.5 Салбарын эрсдэлийн төлөв байдал, холбогдох статистик мэдээллийг нэгтгэн гаргах | - | Мэдээллийн тоо | 2 | 2 | 1 | Мэдээлэл, харилцаа холбооны хяналтаар 2025 оны 1-6 сард хийгдсэн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын үр дүнд гарсан хууль сахин мөрдөлтийн хувь, эрсдэл үүсэх магадлалын хувь, зөрчил арилгуулалтын хувь, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь нийт 4 төрлийн статистик мэдээллийг гаргаж улсын байцаагч нарт танилцуулж, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан. | 100 |
| **Яамны стратегийн зорилт 8. Эрсдэлд суурилсан салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн найдвартай ажиллагааг хангуулах** | | | | | | | | |
| | Зорилт 3. Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ. | - | Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь | - | 100 | 30 | “Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.” Зорилтын хүрээнд 9 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацааны төлөвлөгөөний хэрэгжилт 94.77%-тай байна. | 94.77 |
| | | | Албан шаардлагын хэрэгжилтийн /хувь/ | 85 | 87 | 85 | | |
| | | | Зөрчил арилгалт /хувь/ | 79 | 80 | - | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гомдол мэдээллийн шийдвэрлэлт /хувь/ | 98 | 99 | 98 | | |
| 18 | Арга хэмжээ 3.1 Хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээг хийн, их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах 171 объектуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | - | Шалгалт хийсэн объектын гүйцэтгэл /хувь/ | - | 100 | 28 | Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугээр тогтоолоор баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/63 дугаартай 2025 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай тушаалын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/03 дугаартай удирдамжийн хүрээнд нийт 171 объект төлөвлөснөөс 48 объектод төлөвлөгөөт шалгалт хийсэн. Төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн 159 заалттай 32 албан шаардлага, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | 80 |
| | | | Албан шаардлагын хэрэгжилтийн /хувь/ | 85 | 87 | - | | |
| | | | Хууль сахин мөрдөлт /хувь/ | 78 | 79 | 78 | | |
| 19 | Арга хэмжээ 3.2 Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | - | Зөрчил арилгалт /хувь/ | 79 | 80 | 79 | 1. Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугээр тогтоолоор баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/63 дугаартай 2025 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай тушаалын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/04 дугаартай удирдамжийн хүрээнд 29 объектод урьдчилан сэргийлэх шалгалт | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийж илэрсэн зөрчлийг арилгуулах 80 заалттай 17 албан шаардлага хүргүүлж, 3 аж ахуйн нэгжид 1,800,000 төгрөгний торгуулийн арга авч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>2. Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 09-00/06 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамж, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/197 дугаар албан томилолтоор ажиллуулах хугацаанд өөрчлөлт тухай тушаалын дагуу 2025 оны 2 дугаар сарын 10-аас 18-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Сэлэнгэ баг, Чандмань-Өндөр сумын Улаан асга баг, Эрдэнэбулган сум, Түнэл сум зэрэг газарт баригдсан үүрэн холбооны дахин дамжуулах станцын байр, харилцаа холбооны цамхаг, тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралтын байдалд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэн холбогдох зураг төсөл, стандарт норм дагуу хийж гүйцэтгэх талаар нийт 6 хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажилласан.<br>2. Харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангуулах, болзошгүй байгалийн гамшигт үзэгдэл, гэмтэл, саатал, ослоос урьдчилан сэргийлэх, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын аюулгүй байдал, ашиглалт үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангуулах зорилгоор харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад 09-00-02/001/01 дугаар улсын ахлах байцаагчийн зөвлөмж гаргаж хүргүүлсэн. | |
| 20 | Арга хэмжээ 3.3 Нийслэл, 21 аймгийн теле хяналтын системийн тоног төхөөрөмж, шугам сүлжээний зураг төсөл, угсралт, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | - | Зөрчил арилгалт /хувь/ | - | 50 | 51 | Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугээр тогтоолын хавсралтаар баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/05 дугаартай удирдамжийн хүрээнд 13 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж 35 заалттай 13 албан шаардлага, 64 заалттай 24 зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | 90 |
| 21 | Арга хэмжээ 3.4 Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах зөвлөлд ажиллах | - | Хянан баталгаажуулах үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | 100 | Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажуулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж 2025 оны 1 дүгээр улиралд 7 хуралд оролцож 78 тоног төхөөрөмжид баталгаажилтын гэрчилгээг 3 жилийн хугацаатай шинээр олгож, 96 тоног төхөөрөмжийн хугацааг 3 жилийн хугацаатай сунгах, 4 төхөөрөмжийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэрийг хуралдаанаас гаргаж баталгаажуулсан. | 100 |
| 22 | Арга хэмжээ 3.5 Харилцаа холбооны стандартчиллын техникийн хороонд ажиллах | | Батлагдсан стандартын тоо | 7 | - | 100 | Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А/144 дугаар тушаалаар Харилцаа холбооны стандартчиллын техникийн хорооны гишүүнээр ажиллаж 2025 оны 1 дүгээр хурал Харилцаа холбооны зохицуулах хорооны хурлын танхимд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болж, тус хурлаар 2025 онд шинээр болон шинэчлэн боловсруулах харилцаа холбооны салбарын стандартын төлөвлөгөөг хэлэлцэж батлав. | |
| 23 | Арга хэмжээ 3.6 Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулах | - | Батлуулсан удирдамжийн тоо | 17 | - | 7 | 1. Хяналт, үнэлгээний Үндэсний хороо 2024 оны 02 дугаар тогтоол, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А63 дугаар тушаалын дагуу 09-00/03 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай, 09-00/01, 09-00/02 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай, 09-00/04 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг тус тус боловсруулж батлуулан аймаг, нийслэлийн хяналт хэрэгжүүлэх нэгжүүдэд хүргүүлсэн.<br>2. 1111 авто ХХК-иас албан бичгээр ирүүлсэн гомдлын мөрөөр Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 09-00/06 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай.<br>3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/63 дугаар тушаалын хавсралтаар баталсан хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтын дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 09-00/07 дугаар төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай удирдамж боловсруулж, батлуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | Арга хэмжээ 3.7 Мэдээлэл, харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээг ашиглалтад оруулах улсын комисст ажиллах. | | Улсын комиссоор өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/ | 85 | 100 | 95 | Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7-д заалт, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн дагуу нийт 25 барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан 101 үүрэг даалгавар өгч, 96 үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулж ажилласан. Үүрэг даалгаврын хэрэгжилт-95 хувьтай байна. | 95 |
| 25 | Арга хэмжээ 3.8 Удирдлагаас өгсөн үүрэг, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | - | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ | 98 | 99 | 98 | Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугээр тогтоолоор баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/63 дугаартай 2025 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай тушаалын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/05 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд нийт 24 аж ахуйн нэгж байгууллага, 6 иргэн шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах 11 заалттай 4 албан шаардлага хүргүүлж, 5 иргэнд зөрчлийн тухай дагуу нийт 300000 төгрөгний торгуулийн арга авч үйлдэгдсэн зөрчлийг газар дээр нь арилгуулсан.<br>1. “1111 авто” ХХК- ийн гомдлын дагуу Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^2$ дугаар зүйлийн $5^2$.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 30.2.1, 30.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг | 98 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | журам"-ын 6.1, 6.3.1 үндэслэн Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 09-00/06 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос тусгай дугаарыг олгохдоо Харилцаа холбооны тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг хэрэгжүүлж байгаа эсэхэд тус хорооны холбогдох удирдлага, албан хаагчдын төлөөллийг байлцуулан үзлэг, хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэн 09-00-02/001/02 дугаар улсын ахлах байцаагчийн хамтарсан зөвлөмж гаргаж хүргүүлсэн.<br>2. Тээврийн цагдаагийн газрын зүүн талд байрладаг 150 айлын 4 орон сууцны дунд татагдсан агаарын багана, кабель унжилт үүссэн талаар Нарны зам СӨХ-ийн гүйцэтгэх захирал Ш.Насанжаргалаас 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ирүүлсэн хүсэлтийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр тухайн газар МХС ХХК-ний УБХСГ-ын КШ-32 тасгийн ахлах инженер Э.Лхагвасүрэн, кабелчидын хамт шалгаж үзэхэд тухайн хэсэгт байрлах 2 ширхэг агаарын багана, үндсэн кабель шугам нь харилцаа холбооны багана биш бөгөөд унжилт үүссэн кабелиуд нь эрчим хүч, цахилгааных байсан. Тухайн хэсэгт харилцаа холбооны худаг сувагчлал байхгүй, эрчим хүчний багана дээр татагдсан 2 шилэн кабель унжилтгүй, нисэлт нь хэвийн байсан. Тухайн мэдээллийг Нарны зам СӨХ-ийн гүйцэтгэх захирал Ш.Насанжаргалд мэдэгдсэн<br>3. Дэлхийн банкны санхүүжилтээр ЦХИХХЯ-ны "Ухаалаг засаг 2" төслийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд хэрэгжүүлж буй “Монголын интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах” төслийн гүйцэтгэгчээр Мобинэт ХХК ажиллаж байгаа ба тоног төхөөрөмжийг 2025.06.20-ны өдрийн дотор бүрэн хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Тус төслийн ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах ТНБД-ын 2025.05.06-ны өдрийн А/135 дугаартай ажлын хэсэг байгуулагдсан.<br>4. Иргэн Д.Нямаагийн Засгийн газрын олон нийттэй харилцах 11-11 төвд гаргасан Монгол шуудан ХК-ийн үйлчилгээний 23 дугаар салбарын үйлчилгээний ажилтны зан харьцаатай холбоотой гаргасан өргөдлийг Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/01 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу хяналт шалгалт явуулж, хариуг хүргүүлж, шийдвэрлэсэн. | |
| 26 | Арга хэмжээ 3.9 Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулах, Улсын байцаагчийн шийдвэр үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээллийг шалгах | - | Зөрчил арилгалт /хувь/ | 100 | 100 | 100 | 1. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Мэдээлэл, харилцаа холбооны улсын байцаагчид нийт 10-н зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд явуулсан бөгөөд одоогийн байдлаар улсын байцаагчдын гаргасан шийдвэр, эрх зүйн акттай холбоотой гомдол мэдээлэл ирээгүй байна.<br>2. Нийслэлийн прокурорын газарт Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3, 2.4 дүгээр зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан, эрх бүхий албан тушаалтны судалгааг гаргаж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 03/152 дугаар албан бичиг хүргүүлсэн.<br>3. Нийслэлийн прокурорын газраас ирсэн 2025 оны 03 дугаар сарын 11-ний Ц-1/389 дугаартай албан бичгээр Зөрчлийн тухай хуульд орсон торгох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх, эрхийг хязгаарлах, эрх хасах нэмэгдэл шийтгэл оногдуулсан эсэх талаар авсан судалгааны хариуг тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 03/585 дугаартай албан бичгээр хариу хүргүүлэв | |
| **ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| Зорилт 4. Яамны дотоод үйл ажиллагаатай холбоотой төлөвлөгөөнд санал өгөх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хангаж ажиллах, сургалтад хамрагдах | | - | Саналын тоо<br><br>Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 3<br><br>6 | 5<br><br>6 | 5<br><br>6 | Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөж 87,5 хувьтай хэрэгжүүлэн ажиллаж байна. | 87,5 |
| 27 | Арга хэмжээ 4.1 Албан хаагчдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд санал өгөх | - | Саналын тоо | 2 | 5 | 5 | Яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөлд Салбарын хяналтын газраас хэрэгжүүлэх нийт 5 төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, төслийн танилцуулга, техникийн тодорхойлолт, төсвийн тооцооллыг гаргаж СХОХэлтэст хүргүүлж, тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/01 дүгээр тушаал батлагдсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | Арга хэмжээ 4.2 Төрийн албаны зөвлөл, байгууллагаас зохион байгуулж буй сургалтад тухай бүр хамрагдах | - | Сургалтад хамруулсан албан хаагчдын тоо | 6 | 6 | 7 | 1. Төрийн албаны зөвлөл болон байгууллагаас зохион байгуулсан цахим сургалтад нийт 7 удаа хамрагдаж хувь хүний хөгжил, төрийн албаны хууль эрх зүй болон мэргэжлийн мэдлэг чадвараа дээшлүүлсэн.<br>2. Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн үүргийн дагуу Мэдээлэл, харилцаа холбооны хяналт хариуцсан ахлах шинжээч "Ёс зүйн сургагч багш бэлтгэх" анхан шатны 32 багт цагийн хөтөлбөрт хамрагдаж Ёс зүйн хорооны дарга, Удирдлагын академийн захирлын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/285 тоот хамтарсан тушаалаар № Z1451 дугаар бүхий үнэмлэх авсан. | 100 |
| 29 | Арга хэмжээ 4.3 Төрийн худалдан авах ажиллагааны /А-3/ сургалт хамрагдаж, сертификат авах | - | Сертификат авсан албан хаагчийн тоо | - | 4 | 1 | -Төрийн худалдан авах ажиллагааны /А-3/ сертификат олгох сургалтад Салбарын хяналын газрын 4 албан хаагч хамрагдсан.<br>- Харилцаа холбооны хяналт хариуцсан мэргэжилтэн Г.Гантулга авсан. | 50 |
| 30 | Арга хэмжээ 4.4 Олон улсын байгууллага, гадаад орнуудын ижил төстэй байгууллагатай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, сургалтад хамрагдах | - | Хамтран ажиллаж буй байгууллагын тоо | 1 | 1 | 1 | Салбарын хяналтын газрын дарга С.Цагаанхүү Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Ази, Номхон далайн бүсийн газраас БНХАУ-ын Шэнжэнь хотноо зохион байгуулах "Цахим шилжилтийг эрчимжүүлэх бодлого, зохицуулалтын орчныг идэвхжүүлэх нь" бүсийн санаачилгын семинар хуралд 2025 оны 04 дугаар сарын 26-наас 30-ний өдрүүдэд оролцож суралцсан. | 100 |
| Зорилт 5. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах, цахим системүүдийг харьяа байгууллагуудад шилжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт шалгалтыг материалыг архивлаж хүлээлгэн өгөх, Авлигын эсрэг хууль, | | - | Зохион байгуулсан | 4 | 4 | | Зорилт 5 хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөж төлөвлөгөөний хэрэгжилт 77,5 хувьтай байна | 77,5 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах | | | арга хэмжээний тоо | | | | | |
| 31 | Арга хэмжээ 5.1 Батлагдсан худалдан ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах | - | Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тоо | **2** | 5 | 3 | **1.** "Улсын байцаагч нарын хяналтын хуудас бөглөх, холбогдох нотлох баримтыг бүрдүүлэх, баталгаажуулах, хэмжүүрийн төхөөрөмжийн үр дүнг гаргах үйл ажиллагаанд хэрэглэх төхөөрөмж худалдан авах" /ЦХИХХЯ/20250202026/ дугаартай тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгээр ажилласан. Худалдан авах ажиллагааг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 4 дүгээр сарын 03-ны хооронд зохион байгуулан тендерийг хүлээн авч 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/101 тушаалаар Нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, 05 дугаар сарын 09-ний өдөр барааг хүлээн авч гэрээ дүгнэсэн актыг баталгаажуулан хүргүүлсэн.<br>**2.** Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тушаалд тусгагдсан "Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах /улсын байцаагч нарт/" ЦХИХХЯ/20250602029 дугаартай шууд худалдан авалтын Техникийн тодорхойлолтыг батлуулан 3 аж ахуйн нэгж, иргэнд хүргүүлсэн. Улмаар шалгарсан Алтай натур ХХК-тай Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/117 дугаар тушаалын дагуу 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр ХХАГ/03 дугаартай "Худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулж, тус оны 05 дугаар сарын 22-ны | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдөр барааг хүлээн авч, гэрээ дүгнэсэн актыг баталгаажуулсан.<br>**3.** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025.01.02 өдрийн А/01 тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-д тусгагдсан ЦХИХХЯ/20250603025 дугаар Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарын сургалт зохион байгуулах А/80 дугаар “Арга хэмжээ зохион байгуулах тухай”, А/91 дугаартай “Гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай” тушаалын төсөл боловсруулж батлуулсан. Тус тушаалын хүрээнд сонгон шалгаруулалт зарлаж бага үнийн санал ирүүлсэн “Бадрах чадвар санхүү” ТББ-ийг шалгаруулж Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарын сургалт зохион байгуулах гэрээг хийх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнасан.<br>**4.** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025.01.02 өдрийн А/01 тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-д тусгагдсан ЦХИХХЯ/20250603027 дугаартай “Мэдээлэл харилцаа холбооны салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах” ажлын даалгавар боловсруулж 2025 оны Төрийн нарийн бичгийн даргын 2025.06.09--ний өдрийн А/191 дугаартай “Гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай” тушаалын төслийг боловсруулж батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025.05.30-ны | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрийн 05 дугаар сарын 30-ны 02/1318 дугаар албан бичгээр “Склар” ХХК, “Роял групп” ХХК, “Куантум солюшн” ХХК зэрэг газарт урилга хүргүүлж бага үнийн санал ирүүлсэн “Куантум солюшн” ХХК-тай гэрээ байгуулсан.<br>**5.** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025.01.02 өдрийн А/01 тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-д тусгагдсан ЦХИХХЯ/20250603028 дугаартай “Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын хуудсыг шинээр болон шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах” ажлын даалгавар боловсруулж 2025 оны Төрийн нарийн бичгийн даргын 2025.06.09--ний өдрийн А/192 дугаартай “Гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай” тушаалын төслийг боловсруулж батлуулсан. | |
| 32 | Арга хэмжээ 5.2<br>1. Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан http://shilenkhyanalt.gov.mn/ цахим системийг Хяналт, үнэлгээний үндэсний хороо<br>2. www.shilenkhyanalt.gov.mn-ийн сүүлийн хувилбар болох www.e-khyanalt.gov.mn системийн хөгжүүлэлт дутуу, туршигдаагүй хувилбарыг Хяналт, үнэлгээний үндэсний хороо<br>3. IGOV.MN цахим системийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам<br>4. OM.INSPECTION.GOV.MN цахим системийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн | - | Шилжүүлсэн цахим системийн тоо | 0 | 4 | 1 | 1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр 16-ны өдрийн 01/101 албан бичгээр Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга Э.Одбаярт Хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан http://shilenkhyanalt.gov.mn/ цахим системийг Хяналт, үнэлгээний үндэсний хороо шилжүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн.<br>2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025.03.19-ний өдрийн 01/617 дугаартай албан бичгээр GOV.MN цахим системийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам шилжүүлэх хүсэлтийг хүргүүлсэн хариу ирээгүй байна. | 60 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгааллын яам руу шилжүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | | | 3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025.03.19-ний өдрийн 01/616 дугаартай албан бичгээр GOV.MN цахим системийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд шилжүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. хариу ирээгүй байна. | |
| 33 | Арга хэмжээ 5.3 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах | - | Авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон алба хаагчдын хамрагдалт /хувь/ | 100 | 100 | 100 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ 5 албан хаагч шинэчлэн гаргаж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд тайлагнаж баталгаажуулсан. Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчил гаргаагүй бөгөөд гэрээ байгуулахад 6 албан хаагч ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдүүлэг гаргасан. | 100 |
| 34 | Арга хэмжээ 5.4 Салбарын хяналтын газрын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг ТЗУГ-т хүргүүлэх, баримт бичгийг байгууллагын архивд хүлээлгэн өгөх | - | Хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо | 1 | 1 | 0 | 1. Салбарын хяналтын газрын 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж газрын даргаар хянуулан яамны тайлан хариуцсан ахлах мэргэжилтэн хүлээлгэн өгсөн.<br>2. 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу Салбарын хяналтын газрын төлөвлөгөө, тайлан, хяналт шалгалтын баримт бичиг нийт 3 архивын нэгж үүсгэн байгууллагын архивт шилжүүлэхээр бэлтгэж байна. | 80 |
| | | | Хүлээлгэн өгсөн архивын нэгж | 1 | 1 | 0 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт | | - | Хувиар | 95 | 100 | 100 | Тайлант хугацаанд нийт 43 албан бичиг, 2 өргөдөл гомдол ирсэн байна. Дээрх 43 албан бичгээс 37 нь хариугүй, 26 нь хариутай байх бөгөөд үүнээс 22 нь хууль, журам, тогтоолын төсөлд санал авах, 4 нь улсын байцаагчийн эрх олгуулах, тодруулга авах асуудлаар гаргасан албан бичгүүд байна. Дээрх албан бичгүүдээс 26 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Өргөдөл гомдлын тухайд хүлээн авсан 2 өргөдлөөс 2 өргөдлийг хуулийн хүрээнд шийдвэрлэж иргэнд хуульд заасан хугацаанд албан бичгээр хариу өгсөн. Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100% | 100 |
| 35 | Арга хэмжээ 6.1 Байгууллагын цахим болон дотоодын ээлжит, ээлжит бус шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах | - | Тухайн жилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/ | 100 | 100 | 100 | 1. Нийслэлийн архивын газарт Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчийн хэрэглэх хяналт шалгалтын баримт бичгийн хэвлэмэл хуудаснуудыг хэвлүүлэх тухай 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 03/151 дугаар албан бичиг хүргүүлсэн.<br>2. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын асуудал хариуцсан ахлах шинжээчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Салбарын хяналтын газрын даргаар батлуулсан..<br>3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/82 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 1 этгээд, Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл хүссэн 6 аж ахуйн нэгжийн өргөдлийг магадлан шалгах ажлын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэсгийн хурал 3 удаагийн оролцож холбогдох баримт бичиг, материалтай танилцаж санал өгөв.<br>4. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамны 2, Соёл, Спорт, аялал жуулчлалын яамны 1, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 1, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны 4 нийт 8 Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолын төсөлтэй танилцаж хариу саналыг хүргүүлсэн. Мөн /ЦХИХХЯ/20250202026/ дугаартай тендерийн мэдэгдэл албан бичгийг 3 байгууллагад хүргүүлэн ажилласан.1 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн.<br>5. ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 30-ны А/136 дугаартай тушаалаар батлагдсан "Дижитал засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250103059 дугаартай тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.<br>6. Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт болон хүний нөөцийн удирдлагын шийдвэрт хяналт, шалгалт хийх, төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар тушаалаар баталсан Ажлын хэсгийн Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж 2025 оны 03 дугаар сарын 17-ноос өдрөөс 29-ний өдрүүдэд Сүхбаатар аймгийн Асгат, Эрдэнэцагаан, Дорноговь | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сумдад тус тус албан томилолтоор ажилласан.<br>7. 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан "Стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчин" хэлэлцүүлгийн нэгдсэн хуралдаанд оролцсон.<br>8. ТНБД-ын 2025.05.29-ний өдрийн А/176 дугаар тушаалын хүрээнд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2022-2024 оны хэрэгжүүлсэн "Хөдөө орон нутгийн алслагдсан сумын багт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ төслийн хүрээнд үзүүлж буй харилцаа холбооны хэвийн, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг шалгах захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зорилгоор Хөвсгөл аймагт ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.<br>9. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Бүсчилсэн хөгжил- Төрийн албаны манлайлал нийслэлийн сургалт, зөвлөгөөнд оролцсон. | |
| 36 | Арга хэмжээ 6.2 Удирдлагын шийдвэрээр хууль тогтоомж, дүрэм, журам боловсруулах ажлын хэсэгт ажиллах холбогдох байгууллагаас ирүүлсэн албан бичгийг судалж хариу хүргүүлэх | - | Шийдвэрлэлтийн хувь | 90 | 90 | 90 | 1. Сансрын холбооны кей юү (KU) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хүрээнд тус яамны сайдын 2022 оны 02 сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан "Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний хяналтын журам"-ын хоёрдугаар хэсгийн дагуу хяналтын комисс нь МХС ТӨК-ийн Наран станцад байрлах /Монголсат нэтворкс ХХК/ газрын станц дахь тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, бэлэн байдалтай танилцаж хэмжилт, шалгалт | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийн, үйлчилгээ эрхлэгчээс ирүүлсэн тасалдал, саатлын мэдээ болон гэрээгээр хүлээсэн үүргийг журмын 4 дэх хэсэгт заасны дагуу үнэлж, дүгнэлт хийсэн<br>2. Барилгын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт оролцов.<br>3. Хяналт, үнэлгээний Үндэсний хорооноос ирүүлсэн 01/249 дугаар албан бичгийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаад Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалтай нийцэхгүй байгаа тул тогтоолын төслийг өөрчлөн найруулах талаарх саналыг боловсруулж 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 01/921 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн. | |

---oOo---